

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТӨД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ



СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТӨД ХЭРХЭН ХАМРАГДАХ ВЭ

ХХОАТ-ын хуулийн дагуу хөнгөлөлтөд хамрагдах иргэн нь татварын албаны etax.mta.mn цахим хуудсанд нэвтэрч ХХОАТ-ын тайлан /ТТ-06/, хүсэлтийн хамт 2021 оны 2 дугаар сарын 15-ны дотор цахимаар ирүүлнэ.



Сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдах иргэн
ХХОАТ-ын тайлан цахимаар ирүүлэхдээ дараах материалыг бүрдүүлсэн байна.

Үүнд: Татвар төлөгч иргэний бүрдүүлэх материал

- 1 | Сургуулийн тодорхойлолт /автоматаар, файл/
 - 2 | Сургалтын төлбөр төлсөн цахим төлбөрийн баримтын дугаар /Гадаад сургалтын төлбөр төлсөн баримтын файл/
- ШААРДЛАГАТАЙ ТОХИОЛДОЛД
- 4 | Дагавар, үрчилж авсан хүүхэд болон асран хамгаалагчаар тогтоогдсон асрамж, дэмжлэгт байгаа хүүхэдтэй бол засаг даргын тодорхойлолт /файлаар/
 - 5 | Орлого нотлох баримт /гадаад сургалт/



ОРОН СУУЦНЫ ХӨНГӨЛӨЛТӨД ХЭРХЭН ХАМРАГДАХ ВЭ

ХХОАТ-ын хуулийн дагуу хөнгөлөлтөд хамрагдах иргэн нь татварын албаны etax.mta.mn цахим хуудсанд нэвтэрч ХХОАТ-ын тайлан /ТТ-06/, хүсэлтийн хамт 2021 оны 2 дугаар сарын 15-ны дотор цахимаар ирүүлнэ.



Орон сууцны хөнгөлөлтөд хамрагдах иргэн
ХХОАТ-ын тайлан цахимаар ирүүлэхдээ дараах материалыг бүрдүүлсэн байна.

Татвар төлөгч иргэний бүрдүүлэх материал

- 1 | Үл хөдлөх эд хөрөнгийн серийн дугаар /Y1234567890/
- 2 | Орон сууц худалдан авсан цахим төлбөрийн баримтын дугаар / Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны 2%-ийн баримт /
- 3 | Орон сууц барьсан бол Хөрөнгийн үнэлгээний тайлан /файлын хэмжээ 25mb/
- 4 | Орлого нотлох баримт /файл/
- 5 | Худалдах худалдан авах захиалгын гэрээ /Нотариатаар баталгаажуулсан гэрээг файлаар хавсаргах/

ТАТВАР ТӨЛӨГЧ ШИНЭЭР БҮРТГҮҮЛЭХЭД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Хувь хүнийг татвар төлөгчөөр бүртгэх

Монгол улсад байнга оршин суугч Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хүн бүртгүүлэхдээ дарах материалыг бүрдүүлнэ.

- Иргэний үнэмлэхний хуулбар
- Гадаадын иргэн болон харъяалалгүй хүний хувьд аль улсын иргэн болохыг нотолсон баримт бичиг, гадаад паспорт, Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх газарт бүртгүүлсэн харъяалалгүй хүний түр үнэмлэх
- Цээж зураг /3x4/ 2 хувь
- ТБ-03 маягтаар бүртгэнэ
- Татварын алба хувийн хэрэг нээнэ.

“Татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлий дэвтэр”, татвар төлөгчийн гэрчилгээ олгоно.

Татвар төлөгчөөр бүртгүүлэх үүрэг бүхий бусад этгээдийг бүртгэх

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь байгуулагдсанаас хойш ажлын 14 өдрийн дотор харъяалах татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлэх ба татварын алба хувийн хэрэг нээн, татвар төлөгчийн гэрчилгээг олгоно.

ИРГЭДЭД СУРТАЛЧЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АКТУУД

Татварын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/, дагаж мөрдөж дүрэм журам
Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, дагаж мөрдөж дүрэм журам

ААНОАТатварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, дагаж мөрдөж дүрэм журам

НӨАТатварын тухай хууль, дагаж мөрдөж дүрэм журам

Галт зэвсгийн албан татварын тухай хууль

Хог хаягдлын тухай хууль

Бусад хууль тогтоомж, дагаж мөрдөх дүрэм журам

ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

3.1 Санхүү, төсвийн зохицуулалт

Зорилго: 3.1. Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулах замаар татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэж, татварын орлогын бааз 2020 онд 7697110.4 мянган төгрөг байсныг жил бүр 2 хувиар нэмэгдүүлж, 2024 онд 8331600.0 мянган төгрөгт хүргэнэ.

Зорилт: 3.1.1 Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааны цахимжуулалт 2020 онд 93.9 хувь байсныг 2024 онд 100 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

3.1.1.1 Татварын тайлан буюу цахимаар ирүүлбэл зохих тайлангийн хувийг нэмэгдүүлэх

3.1.1.2 Улс, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жил бүр 100 хувь

Биелүүлэх

3.1.1.3. Иргэдийг и-баримтад холбох ажлыг 100 хувьд хүргэж ажиллах

3.1.1.4. НӨАТатвар төлөгч байгууллагуудын баримт олголтыг сайжруулж, хяналтыг тавьж ажиллах

3.1.1.5 Татварт хамрагдаагүй хэсгийг татварт хамруулж, татварын бааз суурийг нэмэгдүүлэн орлогын эх үүсвэрийг сайжруулах